




## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ХӨТӨЛБӨР

Баримт бичгийн мэдээлэл	
Баримт бичгийн дугаар:	ЖР016
Баримт бичгийн хувилбарын дугаар:	1.0
Хүчин төгөлдөр болсон огноо:	2022.04.04
Мэдээллийн ангилал:	Нээлттэй
Хариуцагч	Дэд захирал

	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Баталсан:	Самдан овогтой Батжаргал	Гүйцэтгэх захирал	
Боловсруулсан:	Баянцогт овогтой Доржсэмбэ	Дэд захирал	

### ӨӨРЧЛӨЛТИЙН ТҮҮХ

Хувилбар дугаар	Огноо (Он/Сар/Өдөр)	Боловсруулсан	Өөрчлөлтийн тайлбар	Хянагдсан	Баталсан
1.0	2022.04.04	Дэд захирал	Анхны хувилбар		



### ТҮГЭЭЛТИЙН ЖАГСААЛТ

Хуулбарын дугаар	Түгээсэн /илгээсэн/ газар	Огноо	Гарын үсэг	Буцаасан	
				Огноо	Гарын үсэг
1.0	Нягтлан бодогчийн 000078 дугаарт шүүгээ	2022.04.04			

### ИШЛЭЛ БАРИМТ БИЧГҮҮД

Д/д	Нэр	Дугаар/Огноо
1	Компанийн тухай хууль	2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр
2	Компаний засаглалын кодекс	2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр
3	Хөдөлмөрийн дотоод журам	ЖР001
4	Нууцын тухай журам	ЖР002

## **АГУУЛГА**

<b>НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО</b> .....	<b>4</b>
<b>ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ</b> .....	<b>4</b>
2.1.Компанийн засаглалын үр ашиг бүхий тогтолцооны үндсийг бүрдүүлэх .....	4
2.2.Хувьцаа эзэмшигчдийн эрх, бүх хувьцаа эзэмшигчдэд адил, тэгш хандах ба өмчлөлийн үндсэн чиг үүрэг .....	4
2.3.Мэргэжлийн хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээл болон бусад зуучлагч .....	4
2.4.Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг .....	4
2.5.Мэдээллийн нээлттэй, ил тод байдал .....	4
<b>ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ</b> .....	<b>5</b>
<b>ХАРИЛЦАХ ХАМТРАН АЖИЛЛАХ</b> .....	<b>5</b>
<b>ТАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ</b> .....	<b>6</b>

**“ФРАНКУРТ КАПИТАЛ ББСБ” ХХК-ИЙН ОРОЛЦОГЧ  
ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ХӨТӨЛБӨР  
НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО.**

**1.1.** Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Компанийн үйл ажиллагаанд ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлэх, компанийн тогтвортой өсөлтийг хангах, үнэ цэнийг бий болгох, стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх, компанийн хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, оруулсан хөрөнгийг хамгаалах, компанийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, санал хүсэлтийг хүлээн авах, харилцан мэдээлэл солилцох, өөрийн бизнес, засаглал санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх бодит мэдээллийг хүргэхэд оршино.

**ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ.**

**2.1. Компанийн засаглалын үр ашиг бүхий тогтолцооны үндсийг бүрдүүлэх**

Компанийн засаглалын үндсэн тогтолцоо нь эдийн засагт үзүүлэх нөлөө, зах зээлийн бүрэн бүтэн байдлыг дэмжсэн үр ашигтай, шударга байх ёстой. Энэ нь хууль дүрэмтэй нийцэж, үр дүнтэй хяналт шалгалт хийх, хэрэгжүүлэх боломжийг хангасан байна. Хянах, зохицуулах, хууль сахиулах байгууллагууд нь өөрийн эрх үүргээ шударгаар мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх эрх мэдэл, хүчин чадал нөөцөөр хангагдсан байх. Мөн тэдний шийдвэр нь цагаа олсон, ил тод, ойлгомжтой буюу тодорхой мөн нийтийн эрх ашигт нийцсэн байх ёстой бөгөөд дотоодын болон гадаадын хамтын ажиллагааг байнга сайжруулж, хөгжүүлэх.

**2.2. Хувьцаа эзэмшигчдийн эрх, бүх хувьцаа эзэмшигчдэд адил, тэгш хандах ба өмчлөлийн үндсэн чиг үүрэг**

Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах болон эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлээд зогсохгүй, бүх хувьцаа эзэмшигчид ялангуяа цөөн хувьцаа эзэмшигчдийг ялгаварлахгүй адил хандах нөхцөлийг бүрдүүлсэн байхаас гадна хувьцаа эзэмшигчид зөрчигдсэн эрхээ үр дүнтэйгээр нөхөн сэргээж авах боломжоор хангах.

**2.3. Мэргэжлийн хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээл болон бусад зуучлагч**

Компанийн засаглалын тогтолцоо нь хөрөнгө оруулалтын гинжин хэлхээний туршид зохистой хөшүүрэг үзүүлж, үнэт цаасны зах зээлийг компанийн сайн засаглалд хувь нэмэр оруулахуйц байдлаар үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.

**2.4. Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг**

Компанийн засаглалын тогтолцоо нь оролцогч талууд болох хувьцаа эзэмшигчид, ажилчид, зээлдүүлэгчид, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид болон бусад оролцогч талуудын эрхийг хууль тогтоомж, хамтын гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, мэдээллээр цаг алдалгүй хангаж оролцогч талуудын хоорондын идэвхтэй хамтын ажиллагааг дэмжихэд чиглэгдэнэ. Компанид болж буй хууль бус эсвэл ёс бус үйлдлийн талаар холбогдох газарт чөлөөтэй мэдээлэх бололцоогоор хангагдсан байх ба ингэснээр тэднийг шахан хавчих байдлаар эрхийг нь зөрчихгүй байх.

**2.5. Мэдээллийн нээлттэй, ил тод байдал**

Компанийн засаглалын тогтолцоо нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа, өмчлөл, болон засаглалтай холбоотой бүхий л мэдээллүүд нь хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргах чухал мэдээллүүд байдаг тул мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, нийтэд нээлттэй байлгах боломжоор хангадаг. Мэдээлэл ил тод байснаар компаниуд хөрөнгө татах болон зах

зээл дээр илүү итгэлцлийг бий болгох боломжийг бүрдүүлэх. Санхүүгийн тайланг хөндлөнгийн, мэргэжлийн аудитын байгууллагаар баталгаажуулж байх.

### **ГУРАВ. КОМПАНИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ.**

**3.1.**Компанийн тогтвортой өсөлтийг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг компани нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1.Компанийн стратеги төлөвлөгөөг гаргаж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

3.1.2.Харилцагч татах, зээлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл, хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл, зээлийн хугацаа зориулалт зэргийг ил тодоор нийтэд мэдээлж үйл ажиллагаагаа өргөжүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулах

3.1.3.Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай зээлийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг байнга эрэлхийлж ажиллах

3.1.4.Харилцагчдад хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэхийн тулд хүний нөөц, техник технологийн дэвшлийг байнга үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллах.

3.1.5.Компанийн үйл ажиллагаатай холбоотой шинээр батлагдаж байгаа хууль, холбогдох эрх бүхий байгууллагуудаас гаргасан журам, эрхзүйн актуудын өөрчлөлтийг дотоодод үйлчлэх журам заавартай тухай бүр нийцүүлэн шинэчилж үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвших.

### **ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ**

#### **ХАРИЛЦАХ ХАМТРАН АЖИЛЛАХ**

**4.1.**Компани нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдийг хуулиар нууцлаагүй мэдээллээр эрх тэгш байдлаар хангах үүрэг хүлээнэ.

**4.2.**Мэргэжлийн хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээл, зуучлагч нарыг компанийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, гаргаж буй бүтээгдэхүүн үйлчилгээ, түүний нөхцөл, үр ашгийн тооцоолол, стратеги төлөвлөгөө зэрэгтэй танилцах боломжоор хангаж ажиллах.

**4.3.**Хувьцаа эзэмшигч нарт жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг танилцуулж санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилж болно. Ногдол ашиг хувиарлахдаа дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

-Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана;

-Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 46.1-д заасан шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэх үүрэгтэй;

-Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчийг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан өдрөөр, хувьцаат компанийн хувьд Компанийн хуулийн 64 дүгээр зүйлд заасан бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлох бөгөөд энэ тухайгаа хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ;

-Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна;

-Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна;

-Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй;

-Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилах бөгөөд компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно;

-Давуу эрхийн хувьцаанд хуваарилах ногдол ашгийг тусгайлан байгуулсан сангаас олгож болно;

-Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна;

-Компанийн тухай хуулийн 46.10-т заасан хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл тухайн компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй;

-Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй;

-Хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ;

-Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана;

-Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ;

**4.4.**Компани нь хөрөнгө оруулагчидтай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулсан мөнгөн дүнгийн хүүг хувиарлан олгох үүрэгтэй.

#### **ТАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ**

**5.1.**Компани нь өөрийн үйл ажиллагааг өргөтгөх, тогтвортой байдлыг сайжруулах зорилгоор гаргаж буй бүтээгдэхүүн үйлчилгээ, түүний төрлүүд, хүү, шимтгэлийн нөхцөл, зээлийн хугацаа, хэмжээ зэргийг вэб хуудас, цахим хаяг, мэдээлэл сурталчилгааны хэлбэрүүдийг ашиглан нийтэд ил тодоор мэдээлэх.

**5.2.**Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарт санхүүгийн жилийн эцсээр аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах.

**5.3.**Стратеги төлөвлөгөө түүний биелэлтийн талаар хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарт санхүүгийн жил дууссан тухай бүр, эсвэл стратеги төлөвлөгөө хэрэгжиж дуусах хугацааны эцэст 60 хоногийн дотор тайлагнах.

**5.4.**Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудад заасан нууц мэдээллийг задлахыг хориглоно.